

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 11/337

НШУС

2010

ИВАН КОРОСТОВЕЦИЙН ТЭМДЭГЛЭЛ ДЭХ “ШИНЭ ТОЛЬ ХЭМЭЭХ БИЧИГ”-ТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ

Т.Баасансүрэн*

• МОНЦАМЭ агентлагийн захирал, түүхийн ухааны доктор (Ph.D.)

Түлхүүр үг: “Шинэ толь хэмээх бичиг”, И.Я. Коростовецийн өдрийн тэмдэглэл, Монголын анхны сонин, Монголын сэтгүүл зүйг үндэслэгч, нийтлэлийн бодлого, сөрөг сурталчилгаа.

Mонголын нийгмийн амьдралд 2011 онд олон чухал үйл явдал болно. Хүннү гүрний 2220 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 805 жил, Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний ялалтын 100 жил, Ардын хувьсгалын 90 жилийн ойтой. Эдгээр түүхэн чухал үйл явдлууд нийгмийн амьдралыг илэрхий идэвхжүүлж байна. Эрдэмтдийн шинэ бүтээл туурвицууд хэвлэгдэж, эрдэм шинжилгээний сонирхолтой хурлууд зохиогдох болов.

Улс нийгмийн амьдралын толь болж ирсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл амьдрал ч тэмдэглэлт үйл явдлаар дүүрэн байна. “Үнэн” сонини 90 жилийн ой, Монголын сэтгүүл зүйг үндэслэгч их соён гэгээрүүлэгч Жамсраны Цэвээний мэндэлсний 130 жилийн ой 2010 онд тохиож байгаа. Монголын хэвлэлийн түүхт 100 жилийн ойг бид 2013 оны 3-р сарын 6-нд тэмдэглэнэ.

Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 100 жилийн ойд зориулж хаант Оросын нэрг дипломатч Иван Яковлевич Коростовецын “Есөн сар Монголд” хэмээх өдрийн тэмдэглэлийн сонирхолтой номыг 2009 онд Улаанбаатарт хэвлэн гаргажээ. Тэрбээр 1912 оны 8-р сараас 1913 оны 5-р сар хүртэлх хугацаанд Монголын нийслэл Өргөөд хаант Орос улсын бүрэн эрхт төлөөлөгчөөр ажиллаж, Монгол-Оросын хоорондын харилцааны шинэ эхлэлийг тавьсан 1912 оны гэрээг байгуулахад голлох үүрэгтэй оролцсон байна. Олон сонирхолтой түүхэн баримтыг тэрбээр өдрийн тэмдэглэлдээ бичиж үлдээжээ. Тэдгээрээ зөвхөн Монголын хэвлэлийн түүхтэй холбоотой хэсэгт анхаарал хандуулж “Шинэ толь хэмээх бичиг” сонин хэрхэн яаж буй болсон талаарх түүхэн баримтыг ахиж нэгэнтээ нягтлан тодотгоыг зорив.

Петербургээс Өргөөд томилогдсон Оросын дипломатч энэ хүнд монгол хэл, ёс заншлыг сайн мэддэг мэргэжилтэн ихэд хэрэгтэй байжээ. Тийм хүмүүс нь тухайн цаг үед буриадууд байсан байна. Иван Яковлевич 1912 оны 10-р сарын

13-ны өдрийн тэмдэглэлдээ Жамсраны Цэвээнтэй уулзаж танилцсанаа ихэд олзуурхан бичсэнээс энэ нь тодорхой мэдрэгдэнэ. Тэрбээр “Жамсранов бол олон талын мэдлэг боловсролтой, ухаалаг хүн учраас ажилдаа туслуулахын тулд би түүнийг урьж уулзвав. Тэр манай орос сургуульд ажиллаж монголчуудыг орос хэлэнд сургадаг байв... Монгол хэл, монголчуулыг сайн мэддэгийн хувьд тэр надад маш их хэрэгтэй байлаа”¹ хэмээн тэмдэглэжээ.

Оросын дипломатч И.Я. Коростовец тухайн цаг үеийн Монгол Улсад соён гэгээрүүлэгч шинж чанартай цаг үеийн шуурхай мэдээлэл, олон улсын байдал, улс төрийн амьдралыг мэдээлэгч сонин, сэтгүүл хэрэгтэйг овсгоотойгоор олж харж чадсан байна. Тэр энэ тухайгаа Ж.Цэвээнд ярьж, санал солилцож байсан нь сонирхолтой баримт юм. 1912 оны 12-р сарын 10-ны өдрийн тэмдэглэлдээ ноён И.Я. Коростовец “Монгол хэлээр хэвлэгдэх сонины талаар Жамсрановтой зөвлөн ярилцлаа. Сонины эрхлэгчээр Петербургт сурдаг буриад ястан Барадинийг ажиллуулахаар санал болгосон ба түүнд энэ тухай захидаар дуулгасан. Сонины нийтлэлийн бодлогын хувьд бүх талаар хараат бус байх болно хэмээн хэтэрхий найдаж болохгүйг би Жамсрановт урьдаас сануулан хэлэв. Үндсэндээ Оросын нөлөөллийг дэлгэрүүлэн сурталчлахын сацуу буриадын салан тусгаарлах үзлээс зайлсхийг ёстой. Гэхдээ буриад хүнгүйгээр ажил явахгүй гэдэг нь жаахан тиймэрхүү. Тэр хүн өөрийн буриадын үзэл суртлыг дэлгэрүүлэхийг бodoх нь мэдээж, гэхдээ буриадуудтай ажиллах амар байдаг юм. Учир нь тэд нар сахилга сайтай, аливаа

зүйлийг үнэн сэтгэлээсээ хийдэг, бас илүү дутуу юм нэхэхгүй, хамгийн гол нь оросуудыг бодвол илүү эрүүл саруулаар сэтгэдэгт байгаа юм. Харин манай эх орон нэгтнүүд, ялангуяа энд амьдардаг орос хүмүүс бол ер нь боловсрол нимгэнтэй нөхдүүд шүү дээ”² хэмээн бичиж үлдээсэн байна.

Э нэхүү сонирхолтой тэмдэглэлээс үзэхэд хаант Оросын Бүрэн эрхэт төлөөлөгч Өргөө хотноо Монгол хэлээр сонин гаргах асуудлаар идэвхтэй хөөцөлдөж байсан нь хардаж байна. Сониныхоо эрхлэгчийг хүртэл товлож, түүнд захидал бичиж санал тавьж байжээ. Жамсраны Цэвээнийг уг сонины үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг мөн санал болгосон бололтой. Гэхдээ буриад ястнуудын, түүний дотор Ж.Цэвээний салан тусгаарлах үзэл бодлоос илэрхий эмээн болгоомжилсон нь мэдрэгдэж байна. Ноён Бүрэн эрхэт төлөөгчийн бодлоор бол уг сонин нь Оросын нөлөөллийг Монголд дэлгэрүүлэх хэвлэл байх учиртай байж.

“Сонины нийтлэлийн бодлогын хувьд бүх талаар хараат бус байх болно хэмээн хэтэрхий найдаж болохгүйг би Жамсрановт урьдаас сануулан хэлэв” гэснээс энэ нь бүр ч тодорхой хардаж байна. Нөгөө талаар ноён И.Я. Коростовецийн дээрх тэмдэглэлээс Монголын сэтгүүл зүйг үндэслэгч Ж.Цэвээний үзэл бодол бас хамтад мэдрэгдэж буйг тэмдэглэн хэлбэл зохилтой. Тэр шинээр гаргах сонин нь нийтлэлийн бодлогын хувьд бүх талаар хараат бус байна гэсэн байр суурийг илүү баримталж байсан бололтой. Энэ баримт Монгол дахь ХХ зууны эхэн үеийн чөлөөт хэвлэлийг үндэслэгч нь Жамсраны Цэвээн мөн

гэсэн бидний өмнөх үндэслэл, үнэлэлт дүгнэлтийг улам үнэмшүүлэн баталгаажуулж байгаагаараа онцгой ач холбогдолтой болно. Тийм ч учраас хаант Оросын Бүрэн эрхэт төлөөлөгч түүнд дээрх анхааруулгыг зориуд урьдчилан сануулж хэтэрхий найдаж хэрэггүй хэмээн ятгаж байжээ. Оросын Бүрэн эрхт төлөөлөгчийн тэрхүү санаа бодлыг бүрэн хуваалцах хүн нь Барадин гэдэг буриад иргэн байсан тул ноён И.Я. Коростовец түүнд Өргөөд монгол хэлээр гаргах сонины эрхлэгчээр ажиллахыг санал болгож захидал бичиж байсан бололтой байна. Гэвч яагаад ч юм Барадин гэгч тэр хүн нь Өргөөд ирээгүй бөгөөд сүүлд “Шинэ толь хэмээх бичиг” сониньг Ж.Цэвээн өөрөө эрхлэн гаргасан түүхтэй билээ. Нөхцөл байдлын эл өөрчлөлт нь Монголд Оросын нөлөөллийг дэлгэрүүлэгч, тэднээс шууд хараат монгол хэл дээрх хэвлэлийг бус харин монголчуудын өөрсдийнх нь үндэсний сонин үүсч хөгжихэд эергээр нөлөөлсөн байна.

Өргөө дэх хаант Оросын Бүрэн эрхт төлөөлөгчийн толгойд монгол хэл дээр сонин гаргах санаа хэрхэн яаж төрсөн тухай сонирхолтой баримтыг И.Я. Коростовец өөрийн тэмдэглэлд бас бичиж үлдээжээ. 1913 оны 1-р сарын 1-ний өдрийн тэмдэглэлдээ тэрбээр “Люба надад Бээжинд монголоор хэвлэгдэн гардаг хоёр сэтгүүлийг үзүүлсэн юм. Тэдгээр нь чулуун барын аргаар хэвлэгдсэн бөгөөд цайр барын хэд хэдэн нилээд чанартай зургуудыг нийтэлсэн байх ажээ. Эдгээр нь Юань Ши Кайн хөрөг, Орос орны талаар болон түүний Монголд явуулж буй хүчирхийлэл гэгчийг харуулсан элэглэлүүд юм. Тэр-

гүүн нүүрэнд нь монголчуудыг хятадуудтай нэгдэхийг уриалсан өгүүлэл гарсан байх ба хавтсан дээр нь Хятадад оршин суудаг таван үндэстнийг билэгдсэн таван өнгөт бүгд найрамдах улсын далбааг зуржээ. Сэтгүүлийн зорилго ойлгомжтой бөгөөд хамгийн гол нь Бүгд найрамдах улсыг сурталчлах, түүний сацуу Оросын нөлөөлөлтэй тэмцэх явдал байв. Эдгээр сэтгүүлийг Монголд нэвтрэн тархахад нь саад хийх хэрэгтэй гэж Люба үздэг юм. Миний хувьд энэ нь төдийлөн үр дүнтэй арга биш бөгөөд илүү идэвхтэй арга барилаар тэмцэх нь зүйтэй гэж бодогддог. Хятадуудтай тэдний өөрсдийнх нь аргаар үзэлцэх хэрэгтэй, тухайлбал Оросын суртлыг дэлгэрүүлэх зорилгоор монгол хэл дээр сонин, сэтгүүлийг гаргах хэрэгтэй байна. Эл зорилгоор би Малиновскийгоос хэвлэлийн машин худалдан аваад, Петербург руу монгол үсгийн хэв захиалсан юм. Котвич надад редактор олоод өгөх байх л даа. Сэтгүүл маань хамгийн гол нь соён гэгээрүүлэх зорилготой бөгөөд аливаа шүүмж, шүүмжлэлээс ангид байх юм¹³ гэж бичсэн байна.

Монгол дахь Хятадын нөлөөллийг сааруулах, оронд нь хаант Оросын нөлөө; суртал ухуулгыг дэлгэрүүлэхэд монгол хэл дээрх хэвлэлийг ашиглах санаа эндээс тод харагдаж байна. Хятадуудтай тэдний өөрсдийнх нь аргаар тэмцэх нь илүү үр дүнтэй гэж ноён И.Я. Коростовец үзэж байжээ. Эл санаагаа хэрэгжүүлэхийн тулд хэвлэлийн машин худалдан авч, Петербург руу монгол үсгийн хэв захиалж байсан байна. Уг сониноо соён гэгээрүүлэгч шинжтэй гэж тодорхойлоод аливаа шүүмж, шүүмжлэлээс ангид байх юм гэж төсөөлж байсан

аж. Гэвч сүүлд "Шинэ толь хэмээх бичиг" сонин нь хамгийн хурц шүүмжлэгч хэвлэл болж хувирсан билээ. Үүнээс үзсэн ч гэсэн сонины нийтлэлийн бодлого дээр ноён И.Я. Коростовец болон Ж.Цэвээн нарын байр суурь ялгарч, зөрж байсан нь тод харагдаж байна.

Хаант Оросын Бүрэн эрхэт төлөөлөгч 1913 оны 1-р сарын 4-ний өдрийн тэмдэглэлдээ "Би Иванов, Малиновский нараас хэвлэх үйлдвэрийг нь 3500 рублиэр худалдаж аваад консулын газрын мэдэлд шилжүүлэн өгөв. Өмнө нь уг үйлдвэрт ажиллаж байсан үсэг өрөгч, механикч хоёр орос хүнийг авч үлдсэн билээ"⁴ гэжээ. Энэ бол тухайн цаг үедээ Монголд орчин цагийн хэвлэлийг хөгжүүлэхэд үзүүлсэн юутай ч зүйрлэшгүй том дэмжлэг туслалцаа байв. Монголд үндэсний хэвлэл үүсч хөгжихэд хэвлэх үйлдвэрийн бааз суурь онцгой хэрэгцээ шаардлагатай байсан нь ойлгомжтой юм. "Шинэ толь хэмээх бичиг" сониныг "Монгол Улсын Гадаад явдлын яам, хаант Оросын Монгол дахь төлөөний сайдын газрын хооронд байгуулсан гэрээний дагуу гаргасан бөгөөд үндэсний дэвшилт ардчилсан үзлийг номлож, соён гэгээрүүлэх чиглэлийн нийтлэлийг зонхилон гаргаж байв. Уг сониныг хэдийгээр Оросын төлөөний сайдын ивээлд багтааж, түүний хэвлэлийн баазад түшиглэн гаргаж байсан боловч эрхлэн гаргагчид нь Монголын дэвшилт сэхээтнүүд

байсан учир үнэн хэрэгтээ хэнээс ч хамааралгүй, нийтлэлийн бие даасан бодлоготой хэвлэл байв"⁵ гэж доктор профессор Л.Норовсүрэн тэмдэглэсэн нь бий. Монголын үндэсний хэвлэлийг үүсгэн байгуулах үйл хэрэгт Монгол, Оросын тал аль аль нь адилхан санаачилга гарган оролцсон байна. Энэ нь дараах тэмдэглэлээс бүр ч тодорхой харагдаж байна. "Монголчууд надад хэвлэх үйлдвэрийн байр олж өгөв. Энэхүү хоёр давхар мөдөн байшинд өмнө нь хятадууд сууж байжээ. Би ч баяртай байлаа, учир нь байшин хэрэв олдохгүй бол шинээр барих хэрэгтэй болно шүү дээ"⁶ гэсэн байна. Ноён И.Я. Коростовец цааш нь бүр ч сонирхолтой зүйлийг

«
Жамсранов бол олон талын мэдлэг боловсролтой, ухаалаг хүн учраас ажилдаа туслуулахын тулд би түүнийг урьжс уулзав. Тэр манай орос сургуульд ажиллах эс монголчуудыг орос хэлэнд сургадаг байв... Монгол хэл, монголчуудыг сайн мэддэгийн хувьд тэр надад маш их хэрэгтэй байлаа.
»

тэмдэглэн үлдээсэн байна. Тэрбээр 1913 оны 1-р сарын 30-ны өдрийн тэмдэглэлдээ "Гаргахаар төлөвлөж буй монгол сониноо би "Шинэ толь хэмээх бичиг" хэмээн нэрлэхээр шийдэв. Энэ нэрийг Жамсранов бодож олсон бөгөөд тэрээр манай сониныг зөвхөн шинжлэх ухааны чиглэлээр бичдэг байлгахыг хүсдэг юм. Энэ тухайд би санал нийлдэггүй бөгөөд сониндоо улс төрийн хэлтэс байгуулж, үйл явдлыг шуурхай товчоолон нийтлэхийг зорьдог байв"⁷ гэжээ. Эндээс наад зах нь хоёр зүйлийг маш тодорхой ойлгож болохоор байна. Монголын хэвлэлийн анхдагч нь болж түүхэнд тодорсон "Шинэ толь хэмээх бичиг" сонины нэрийг их эрдэмтэн, соён

гэгээрүүлэгч Ж.Цэвээн өөрөө бодож өгсөн гэдэг нь ахин батлагдаж байна. Сонины нэр нь нийтлэлийн жанжин шугамаа тодорхойлдог тул энэ нь тун чухал юм. Шинэ дэвшилт бүхнийг, түүний дотор шинжлэх ухааны ололт амжилтыг нийтлэлийн бодлогынхоо манлайд тавих ёстой гэж Ж.Цэвээн үзэж байжээ. Харин ноён И.Я. Коростовец бол бүр өөр өнцгөөс буюу цэвэр улс төрийн эрх ашгаа урьтал болгож байсан байна.

Ноён И.Я. Коростовец 1913 оны 3-р сарын 6-ны өдрийн тэмдэглэлдээ "Өнөөдөр миний Монгол хэл дээрх "Шинэ толь" буюу "Новое зеркало"-гийн анхны дугаар гарлаа. Бүгд 200 ширхэг хэвлэгджээ. Сониниг монголчууд ашиглахад дөхөмтэйг бодолцож дээлийн энгэртээ өвөртлөх эсвэл халаасанд багтахуйц жижигхэн дэвтэр хэлбэртэйгээр гаргажээ. Худалдах үнэ нь 10 копейк. Усэг нь муухан болж, учир нь Петербургээс захиалсан хэв нь ирээгүйгээс⁸ хэмээжээ.

"Шинэ толь хэмээх бичиг" сонин бол XX зууны эхэн үеийн Монголын нийгмийн амьдралд тохиосон ховорхон том үйл явдал байв. Анхны дугаараасаа л нийгмийг бүхэлд нь нойроос сэрээж, түмэн зүйлийг бадруулан элдэв ухааныг нэвтрүүлж эхэлжээ. Энэ нь эсэргүүцэл тэмцэлтэй тулгарсан нь нэг биш юм. Нэгэн тохиолдлын тухай ноён И.Я. Коростовец тэмдэглэлдээ дэлгэрэнгүй бичиж үлдээсэн байна. 1913 оны 3-р сарын 25-ны өдрийн тэмдэглэлдээ тэрбээр "Шинэ толь хэмээх бичиг" сонины маань анхны дугаар гарахад Гандангийн лам нарын дотор бөөн түгшүүр дэгдлээ. 3-р сарын 6-нд гарсан

тэрхүү дугаарын агуулгыг танилцуулваас: 1. Дэлхийн бөмбөрцөг, гаригийг бүрдүүлэгч хэсгүүд ба уур амьсгалын бүсүүд. 2. Дэлхийн бөмбөрцгийн улс орнууд. 3. Халуун ба хүйтэн уур амьсгал, салхи, үүл болон агаар мандал дахь байгалийн үзэгдлүүд, 4. Аянга, цахилгааны талаар, 5. Соёлын төвшнүүд (ялгаанууд), тэнүүлч, нүүдэлч ба суурин амьдралын хэвшил, 6. Худалдаа ба тээврийн харилцаа, 7. Төр ба засаглалын хэлбэрүүд, 8. Орос-Монголын харилцаа, 9. Монголын элчин Петербургт хүлээн авсан нь, 10. Элдэв үзэгдэл: дэлхийн бөмбөрцөг дээр амьдрал үргэлжлэх хугацааны тухай. Манай гариг бөмбөг хэлбэртэй байдаг тухай өгүүлэл нийтлэгдсэн нь лам нарын ундууцлыг ихэд хүргэсэн юм. Буддын сургаалаар бол газар дэлхий нь хавтгай хэлбэртэй бөгөөд далайгаар хүрээлэгдсэн байдал ажээ. Аянга цахилгаан, жилийн дөрвөн улирал болоод дэлхийн улсуудад цагийн зэрүү байдаг тухай дурдсан нь тэднийг улам ч бачимдуулав. Лам нар Гэгээнтэнд гомдол гаргасны зэрэгцээ буддын шашны сургаалыг зөрчигчдийн эсрэг хэрхэхээ зөвлөлдөж буй бололтой. Тэд голчлон Жамсрановыг буруутгаж, ард олны бүдүүлэг, харанхуй байдал, мухар сүсгийг ашиглан завшиж буй лам нарынхаа нэр хүндийг санаатайгаар гутаасан гэж зэмлэж байгаа юм"⁹ гэж бичсэн байна.

Анхны дугаарын нийтлэл Монголын нийгмийн дээд давхарга, ялангуяа Бурханы санваартан лам нарын дунд сандрал тэвдэл үүсгэсэн нь маш тодорхой мэдрэгдэж байна. Богд хаанд гомдол мэдүүлж "Шинэ толь хэмээх бичиг"-ийн эрхлэгч Ж.Цэвээнийг буруутган зэмлэж

эхэлжээ. Энэ бол "Шинэ толь хэмээх бичиг" сонины нийтлэл тухайн цаг үеийн Монголын нийгэмд ямархуу хүчтэй нөлөөлж эхэлсний яруу тод жишээ юм. Соён гэгээрүүлэгч их эрдэмтэн Ж. Цэвээн өөрийн нийтлэлийн бодлого, байр суурь дээрээ хэрхэн баттай зогсож чадаж байсныг эндээс бас давхар харж болохоор байна. Тэр бэрхшээлийн өмнө хэзээ ч сөгдөж байсангүй. "Шинэ толь хэмээх бичиг" сониныг Монгол дахь Оросын төлөөний сайдын ивээл дор, тэдний хэвлэлийн баазад түшиглэн гаргаж байсан нь харин ч зарим талаар Ж.Цэвээн, түүний хамтран зүтгэгчдэд нөмөр нөөлөг болж байжээ. Энэ тухай "Академич Б.Ренчин "Шинэ толь хэмээх бичиг" гэдэг тэр үедээ шинэ цагийн боловсрол түгээх зорилготой сэтгүүлийг Оросын Консулын харьяанаа байсан орос үсгийн хэвлэлийн хорооны дэргэд байгуулсан учир хуучин ёсыг хэрхэвч халахгүй гэсэн үзэл хадгалах ноёд, түшмэд санааны дураар тэр бичгийг зогсоон хааж арай чадахгүй байсан гэж уг сэтгүүлийг нийтлэгч Ж.Цэвээн авгай ярьдагсан хэмээн бичсэн билээ¹⁰ гэж доктор, профессор Л.Норовсүрэн "Монголын нийтлэл" номынхоо тэргүүн дэвтэрт бичсэн нь дээрхийг давхар нотолж байна.

Богд хаантан, лам хуврагуудын эсэргүүцлийг намжаахын тулд Ж.Цэвээн эрхлэгч янз бүрийн арга чарга хэрэглэж, заримдаа Бурхан багшийн сургаал, судар тэргүүтнийг хүртэл хэвлэн нийтэлж ая эвийг нь олж байсан тухай доктор Г.Дэлэг, Л.Норовсүрэн нарын зэрэг эрдэмтэд өөрсдийн судалгааны бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Үүнийг ноён И.Я. Коростовецийн эл тэмдэглэл ч

дэвхар баталж байгаа нь сонирхолтой юм. Тэрбээр 1913 оны 3-р сарын 31-ний өдрийн тэмдэглэлдээ "Толстойн "Будда" хэмээх алдартай туужийг Жамсранов монгол хэлнээ хөрвүүлсэн бөгөөд түүнийг нь бид нар үйлдвартээ ном болгон хэвлэн гаргалаа. Mash хямдхан ердөө нэг копейкоор зарсан учраас гарсан өдөртөө л борлогдсон, монголчууд цааш нь бие биедээ 20 копейкоор худалдаж байв. Тэгэхээр тэдэнд оюуны тэжээл ямар ихээр дутагдаж, мэдлэгээр ямар их цангаж шинэ зүйлийг мэдэхийг хүсэмжилж байгаа нь илт байна"¹¹ гэжээ. Энэ бол эрхлэгч Ж.Цэвээн туйлын авхаалж самбаатай ажиллаж, зөрчил тэмцлийг зөвлөн, хүмүүсийн ая эвийг эвтэйхэн олж чаддаг хүн байсныг батлан харуулж байна.

Э нэ мэт "Шинэ толь хэмээх бичиг" сонинтой холбоотой цөөнгүй сонирхолтой мэдээллийг хаант Оросын Бүрэн эрхт төлөөлөгч ноён И.Я. Коростовецийн өдрийн тэмдэглэлээс олж үзлээ. Оросын дипломатчийн 1912-1913 онд Өргөө хотноо хөтөлсөн өдрийн тэмдэглэл дэх дээрх мэдээллүүд нь "Шинэ толь хэмээх бичиг" сонин, түүнийг эрхлэн гаргагч Ж.Цэвээний талаар нэмэлт мэдээлэл өгч байгаагаараа онцгой ач холбогдолтой юм. Нөгөөтэйгүүр ноён И.Я. Коростовецийн өдрийн тэмдэглэл дэх дурдсан мэдээллүүд нь Жамсраны Цэвээн бол Монголын сэтгүүл зүйг үндэслэгч, Монголын тогтмол хэвлэлийг үүсгэн байгуулагч мөн гэсэн бидний үзэл баримтлал, үнэлэлт дүгнэлтийг улам ч хөдөлшгүйгээр баталж байгаагаараа нэн чухал болно. Ж.Цэвээн бол XX зууны эхэн үеийн Монгол дахь чөлөөт

хэвлэлийг үүсгэн байгуулагч хосгүй гавьяатан юм.

Ишлэл

¹ Коростовец И. Я. 2009. Есөн сар Монголд. (Оросын бүрэн эрхэт төлөөлэгчийн 1912 оны 8-р сараас 1913 оны 5-р сар хүртэлх хугацаанд Монголд хөтөлсөн өдрийн тэмдэглэл). УБ., 120 дахь тал.

² Мөн тэнд, 202 дахь тал.

³ Мөн тэнд, 236 дахь тал.

⁴ Мөн тэнд, 239 дахь тал.

⁵ Норовсурэн Л. 2004. Монголын нийтлэл (тэргүүн дэвтэр). УБ., 256 дахь тал.

⁶ Коростовец И. Я. Дурд. зох., 285 дахь тал.

⁷ Мөн тэнд, 273 дахь тал.

⁸ Мөн тэнд, 225 дахь талд харна уу.

⁹ Мөн тэнд, 241-242 дахь тал.

¹⁰ Норовсурэн Л. Дурд. зох., 257 дахь тал.

¹¹ Коростовец И. Я. Дурд. зох., 249 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баансурэн Т. 2009-2010. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. 1-5 дэвтэр. УБ.

2. Коростовец И. Я. 2009. Есөн сар Монголд. (Оросын бүрэн эрхэт төлөөлэг-

чийн 1912 оны 8-р сараас 1913 оны 5-р сар хүртэлх хугацаанд Монголд хөтөлсөн өдрийн тэмдэглэл). УБ.

3. Норовсурэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тэмдэглэл (тэргүүн дэвтэр). УБ.

4. Норовсурэн Л. 2004. Монголын нийтлэл (тэргүүн дэвтэр). УБ.

Резюме

Настоящая статья посвящена основателю монгольской журналистики, известному просветителю и учёному Жамсрангийн Цэвээну. Автор, на основании выпуск из дневника русского дипломата Ивана Яковлевича Коростовца, полномочного представителя царской России в Урге в период с августа 1912 года по май 1913 года, подробно показывает роль, которую сыграл Ж.Цэвээн при выпуске первой монгольской национальной газеты. Период с августа 1912 года по май 1913 года являлся определяющим в политической жизни Монголии, когда решался вопрос о её независимом существовании от великих держав. И. Я. Коростовец, сыгравший одну из главных ролей при установлении новых русско-монгольских отношений, оставил бесценные замечания о Ж. Цэвээне и первых номерах "Шинэ толь хэмээх бичиг".